

## ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШИЙН ХӨГЖИЛ: БИЕ ДААН СУРАЛЦАХ АРГЫН ҮР НӨЛӨӨ

Wang Lian Hua, ӨМБИС

### Abstract

One of the most challenging issues to improve and extend the preschool education system and its implementation is to prepare specialized teachers. For preschool teachers, the best method to improve their training methodology is to be specialized on their majors and modify training methodology. Enhancing educational level and knowledge regularly appeals to the main concept of educational organization that issuing qualified education for students. The methods to study individually include the followings: necessity, one's own experience, and regular learning.

In the technological 21<sup>st</sup> century, learning individually is essential for everyone not just for preschool teachers. For teachers, it's essential to improve their professional skills regularly for leading, managing, and issuing qualified knowledge for students. The most appropriate method to enhance the education capacity of preschool teachers is to learn individually.

### Түлхүүр үг

Бие даан суралцах, тусгайчилсан, багшийн боловсрол, цэцэрлэгийн багшийн хөгжил, хөгжүүлэх хөтөлбөр, бие даан хөгжих

### Удиртгал

Бид багшлах ур чадваруудыг цаг хугацааны явцад хэрхэн эзэмшдэг талаар судалж, багш бэлтгэх сургалт, мэргэжлийн хөгжлийн талаар судалгаануудыг ул суурьтай нягталж энэхүү судалгааны үр дүнгээ та бүхэнтэй хуваалцаж байгаа болно. Боловсролын байгууллагууд үр өгөөжтэй багшлахуйн аргагүйг багшийн мэргэжлийн хөтөлбөр боловсруулахад хэр ашиглаж байна вэ? гэдэг асуудал сонирхол татна. Гэвч боловсролын талаар судалгаа хийж буй судлаачид багш ажлын байран дээрээ өөрөө өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөрүүдээр дамжуулан багшлахуйн чанарыг хэрхэн сайжруулах тодорхой аргыг үр дүнтэйгээр тусгаж практик дээр нэвтрүүлэхэд анхаарч ажиллахгүй, хүчин зүйлсийн илрүүлсэн судалгааг хийж өөрийн эрдэм шинжилгээний ажлын хүрээнд тайлагнаж байгаа нь хангалтгүй хэмээн дүгнэж болмоор санагдана.

Дэлхий дахин мэдлэг боловсролыг чухалчлан үзэж, сайжруулалт, шинэчлэл өөрчлөлтийг цаг хугацаа орон зайтай уялдуулан өдрөөс өдөрт сайжруулах зайлшгүй шаардлага зүй ёсоор урган гарч байна. Тэр дундаа хамгийн том хөшүүрэг нь багш гэдэг нь тодорхой юм. Энэ чиглэлээр ч олон улсын байгууллагууд, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг сургалтын төвүүд мэргэшсэн, тусгай мэргэжлийн багш нарын боловсролын түвшин, тэдгээрийн хичээлийн арга аргачлалыг олон талаас нь судалсан байдаг. Бие даан суралцах аргыг судалсан нь багш ажлын

байрандаа суралцах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх эрмэлзлэгийг төлөвшүүлэх түүгээр дамжуулан мэргэжил дээшлүүлэх, мэдлэг чадвараа ахиулахад онцгой ач холбогдолтой билээ. Багшийн хөгжил гэдэг нь багш бэлтгэх сургуульд элсэн орж төгсөөд тэтгэвэрт гарах хүртлээ албан ба албан бус замаар олж авсан суралцах туршлагын нааштай өөрчлөлтийн үйл явц юм.

Сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжтэй болгох чиглэлээр хийх хамгийн чухал асуудлын нэг бол мэргэшсэн багш боловсонхүчнийг бэлдэх асуудал юм. Цэцэрлэгийн багш нарын сургалтын арга барилаа дээшлүүлэх, мэргэших асуудал нь тэдний өөрсдөө бие даан суралцах, аливаа сургалтын үйл ажиллагаагаа сайжруулах хэрэгцээнд таарах хамгийн шалгарсан арга билээ. Мэдлэг боловсролын түвшин амьдралынхаа хугацаандаа тасралтгүй байнга нэмэгдүүлэх, сурахыг эрэлхийлэх нь чанартай боловсролыг суралцагчдад олгох гэсэн боловсролын байгууллагын үндсэн үзэл баримтлалтай нийцэх юм. Ажлын байран дээр багш нарыг суралцах урам өгөх, сэдэлжүүлэх, үр шимийг ойлгуулах нь удирдлагын хариуцлага (Оюун, Ц, Түмэндэмбэрэл, Д, 2002, х-54) байдаг. Бие даан суралцах арга нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Хэрэгцээт чанар
  - Туршлагад тулгуурласан чанар
  - Тасралтгүй суралцах чанар зэрэг юм.
- Техник технологи хөгжсөн XXI зуунд

\* ✉ 55696190@qq.com

бие даан суралцах нь цэцэрлэгийн багш гэлтгүй хэн хүний хэрэгцээ шаардлага болоод байна. Манлайлах, удирдах, сурагчдад зөв оновчтой мэдлэг боловсрол олгоход боловсролын байгууллагын ажилчид зогсолтгүй суралцаж цаг үеэсээ хоцрохгүй байх нь зүйн хэрэг. Цэцэрлэгийн багшийн боловсролын чанарыг сайжруулах, нийгэмд өөрийн байр сууриа дээшлүүлэх зэрэгт хамгийн оновчтой арга бол бие даан суралцах арга юм.

1. Цэцэрлэгийн багшийн бие даан сурах тухай агуулгыг задлан шинжилсэн нь Сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс судалбал сурах гэдэг нь бодгаль биеийн туршлагаас үүссэн үйл ажиллагаа, чадвар болон сэтгэцийн хэлбэрийн харьцангуй тогтвортой, удаан хувиралтыг зааж байна.

Энэхүү ухагдахуунд доорх 3 талыг чухал гэж үзсэн байна.

- Суралцахын хамгийн гол зорилго нь заавал ямар нэг төрлийн өөрчлөлттэй байх хэрэгтэй.
- Энэ өөрчлөлт нь гол хэсэг болон орчин тойрны харьцангуй хувиралтаас үүсдэг.
- Урт удаан хугацаа зарцуулагдана.

Иймээс тасралтгүй хөгжье гэвэл заавал суралцах хэрэгтэй. Ялангуяа багш болох хүмүүс тасралтгүй суралцах нь боловсролын үндсэн үзэл санааг гүйцэлдүүлэх чухал арга зам болно.

Бие даан суралцах нь санаачилгатай, өөрийн санаачлагчаар хийх суралцлага болсны хувьд, сурагчийн сурах үйлийн илрэл болон насан туршийн хөгжилд чухал ач холбогдолтой болохоор, зайлшгүй одоо үеийн судлаачдын судалгааны чухал объект болсон юм.

Америкийн судлаач Пинтрич: “Бие даан суралцах гэдэг нь нэг зүйлийн хөдөлгөөнт, бүтээлч чанартай явц, суралцагч юуны түрүүнд зорилго төлөвлөгөөгөө тодорхойлж, дараа өөрийн мэдрэмжээр уг үйлдэлдээ хяналт тавьж, зохицуулалт хийх эзэмших явдал юм” гэж тодорхойлсон байна.

Хятадын эрдэмтэн Жун Чи Чуан бие даан суралцах гэдэг нь “Бодгаль биеэс суралцах төлөвлөгөөгөө тодорхойлж, бие даан суралцах нь аргаа сонгох, суралцах явцаа хянан, өөрийн сурсан үр дүндээ үнэлэлт хийх явц болно” гэж дүгнэсэн байдаг. Багшийн хөгжүүлэх арга зам дотроо бие даан суралцах нь илүү үр дүнтэй хэмээн үзэж болно. Учир нь судалгаа хийх, эрдэм шинжилгээ, сургалтын бүтээл туурвих, хурал, семинар, дадлагад оролцох нь (Оюун. Ц, Түмэндэмбэрэл. Д. 2002, х-50) бие даан хөгжих чухал хэрэгсэл болно.

Судлаач эрдэмтдийн судалгааг үндэслэвэл, бие даан сурахад тууштай, хариуцлагатай, санаачилгатай, зохицуулах чанарын нийлмэл ойлголт гэдэг нь тодорхой харагдаж байна. Цэцэрлэгийн багшийн бие даах сурах нь сурагчийн сурахдаа харьцуулбал суралцах орчин нөхцөл эрс тэс ойлголт юм. Цэцэрлэгийн багш нь нэн илүү өөрийн биеийн тусгай мэргэжлийн хэрэгцээ болон түүнийг сайжруулахаар уг санаагаа болгосон байдаг. Иймээс бие даан сурах гэдэг нь өөрийнх амьдрал үйлдэл болон өөрт хэдийн байгаа туршлага дээр суурилж, санаачилгатай идэвхтэйгээр биеэ жолоодон хамаарч, сурган хүмүүжил заан сургалтын үр ашгийн нэмэгдүүлэхээр ажилсан тусгай мэргэжлийн хөгжлийн ажиллагаа болно. Бодитойгоор хэлбэл:

- Цэцэрлэгийн багш хүүхдүүдэд мэдлэг чадвар олгох үүрэгтэй. Хамгийн гол нь өөрийн бодитой хэрэгцээ болон дур сонирхолдээр үндэслэж санаачилгатайгаар сургалтын үйл ажиллагааг явуулах
- Цэцэрлэгийн багш зарим үед хичээлийн төлөвлөгөөг, үйл ажиллагааны явцыг өөрөө зохицуулдаг, бусдын нөлөөллийг хүлээж авдаггүй.
- Сургалтын үйл ажиллагаа нэг талаар цэцэрлэгийн багшийн бүхий л ажил амьдралд нягт холбоотой байдаг.
- Сурах нь цэцэрлэгийн багшийн бодитой орчны нөлөөллөөс гарч чадахгүй бөгөөд боловсролын үүсэж асуудлыг шийдвэрлэхээр зорилго болгодог.
- Сурах нь цэцэрлэгийн багшийн санаачилгатай, өөрийн биеийн биелэл тусгай мэргэжлийн хөгжлийг эрэлхийлэх явц болохоор ер нь чанга хүчтэй дотоод хөдөлгөгч хүч, идэвхтэй сэтгэмжийн ойлголт, ухамсар, өөрийн үзэл бодолтой нягт холбогдож байдаг.

2. Цэцэрлэгийн багшийн бие дааж сурах мөн чанарын онцлог

Цэцэрлэгийн багш гэдэг нь 3-6 насны буюу бага насны хүүхдүүдэд хүмүүжил олгодог тусгай мэргэжлийн боловсон хүчин болно. Цэцэрлэгийн багшийн ажил нь тус биеийн онцлогтой шинж чанар орлуулж дийлэхгүй онцлог талуудтай байдаг. Цэцэрлэгийн багш нар бие даан сурах нь хэрэгцээт чанар, туршлагад тулгуурласан чанар, тасралтгүй чанартай байдаг.

Хэрэгцээт чанар

Цэцэрлэгийн багш нарын сургалтын ажил

нь практик үйлдэлтэй байж, сургалтын явцад гарах асуудлыг шийдвэрлэхэд багш байнга өдөр тутамд өөрийн мэдрэмж, туршлагаар дүгнэлт хийдэг. Энэ мэдлэг нь бусдаас сурсан мэдлэг биш, харин тухайн багш өөрийн туулж өнгөрөөсөн амьдралын туршлага дээр суурилна. Иймээс багшийн хөгжих шат дарааллын хамгийн чухал хэсэг нь практик талын мэдлэгийг тасралтгүй хуримтлуулахад оршино.

Цэцэрлэгийн багшийн тусгай мэргэжлийн хөгжил нь ямар нэгэн онолын системд тулгуурлах биш, харин тухайн үед өөрөө санаачилгатай шинэ онол шинэ мэдрэмжээр, тухай бүрд дүгнэлт хийж, төрсөн сэтгэгдэл зэргээ өөрийн ажлын онцлог давуу тал болгон, үүнтэй хамтатгаад бие даан сурах шинийг эрэлхийлэх шинж чанарыг өөртөө суулгаснаар аж амьдрал болон ажлын бүтээмжид асар сайнаар нөлөөлдөг байна. Би юуг хийе гэвэл юуг сурна, юуг сурна гэвэл юуг хийнэ гэсэн зарчмаар ажиллах нь гол агуулга болно. Тиймээс багш нар шинэ санаа туршлагын үүднээс өөрсдийгөө өөрчилж, хөгжүүлэхийн тулд хуримтлуулсан мэдлэг, туршлага, итгэл үнэмшлээ оношлоод дутагдалтай талыг ойлгох хэрэгтэй. Өөртөө шүүмжлэлтэй хандах нь бүхий л хөгжил хөдөлгөөний явцад тасралтгүй суралцах боломжийг нээнэ (Берт Криймерс, Леонидас Кириакайдс, Панайотис Антониа. 2013, х-33).

#### Туршлагад тулгуурласан чанар

Цэцэрлэгийн багш нар нь нялх хүүхдийг асран халамжлах, сурган хүмүүжүүлэх үүрэг давхар хүлээж байдаг. Тэд нялх хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хариуцахаас гадна, тэдэнд ойлгомжтойгоор амьдралын утга учир, хүн болохын үнэ цэнэ, юуг хэрхэн хийх зэрэг анхан шатны онолын биш амьдралын арга ухааны хамгийн анхны багш нь байдаг. Гэхдээ хэт нэг талыг баримтлахаас зайлсхийж онолын асуудлыг задлан шинжилж хүүхдүүдэд сонирхолтой байдлаар хичээлийг орох нь хүүхдүүдийн ирээдүйн боловсролын төлөвшилтөд асар сайнаар нөлөөлдөг байна.

#### Тасралтгүй суралцах чанар

Өөрийн үйл хөдлөлөөр дамжуулан хүүхдүүдэд тасралтгүй суралцах сэтгэгдэл урам зориг, төрүүлэхээс гадна, тухайн багшид өөрт нь, хурдацтай хөгжиж байгаа мэдээллийн зуунд мэдээ мэдээллээс хоцрохгүй байх үндэс нь болдог гэж хэлж болно. Үр дүнд нь суралцагч нь цаг үетэйгээ тохирсон мэдлэгийг багшаас олж авах үүд хаалга нь болж өгөх юм.

### 3. Багш бие даан суралцах хандлага нь тун

чухал ач холбогдолтой юм.

Нийгэм хөгжлийн дагаад цэцэрлэгийн багш нарын сурах мэдэх зүйлс маш ихээр нэмэгдсэн ба энэ нь хувь хүн албан байгууллагаас биш нийгмээс орчин тойрноос багшид тулгаж байгаа үүрэг юм. Багш нар мэдлэг мэдээллээ заавал өөрөө олж мэдэж нээн хөгжүүлэх шаардлагатай. Хүмүүс тасралтгүй суралцаж байж нийгмийн өөрчлөлт хурдыг дагаж дийлнэ. Америкийн судлаач Бартийн судалгаагаар их сургуулийн оюутан сургууль төгсөөд дараа нь ажилд ороход хэрэгсэх чадварын 98 нь хүрээлэн буй орчин нийгмээс эрэлттэй гэж байдаг гэсэн судалгаа хийсэн байна. Үүнээс харахад шинэ цаг үеийн цэцэрлэгийн багш нь тасралтгүй нийгмээс суралцаж, өөрийн мэдлэгээ нэмснээр ахиц дэвшилтэй байж, тусгай мэргэжлийн үзүүлэлтээ биелүүлж чадах юм.

Сурахын хэлбэрийн нийгэм нь тухайн багшид өөрийн тусгай мэргэжлийн хамгийн чухал асуудлыг шийдвэрлэхэд туслах арга зам юм.

- Бие даан суралцагч нь боловсролын этгээд байснаас сурах нь гол асуудал болж хувирсан байдаг.
- Тухайн сэтгэгдэл нь өөрийн дур сонирхол, зорилт дээр үндэслэдэг.
- Бие даан суралцахын хамгийн чухал зүйл бол тасралтгүй суралцах явдал.

Суралцах агуулгаа өөрөө сонгож идэвх санаачилгатай байх хэрэгтэй. Суралцагч нь өөрөө хүсэл эрмэлзлээ сэдэлжүүлнэ. Хяналт, дүгнэлт, эргэцүүлэл хийх гэх мэт арга аргачлалаар байнгын өөртөө хяналттайгаар суралцана.

Нөгөө талаас орчин цагийн цэцэрлэгийн багш нар компьютер, тоног төхөөрөмж өндөр хөгжсөн энэ үед мэдээ мэдээллийг интернет, сонин сэтгүүл, сургалт семинар гээд бүх эх үүсвэрээс авахад илүү амар хялбар болсон.

Бие даан суралцах нь эдгээр давуу талтай. Энэ нь бусад уламжлалт хэлбэр, арга барилтай адилтгаж болшгүй давуу тал ихтэй байдаг.

- Суралцах цаг болон орон зайд хязгаарлагдахгүй, компьютер болон интернет байхад, багшаас өөрийн байдлаар үндэслэн суралцах цаг болон орчныг тогтоож болно.
- Мөн илүү сонирхолтой байна.
- Суралцагч багш өөрийн суралцах агуулгаа чөлөөтэй сонгож, суралцах төлөвлөгөө тогтоож, өөрийн хэрэгцээнд үндэслэж зорилттой суралцаж болно.
- Мөн нэг хэвийн баригдмал байдлаас эрс тэс байж, хүрээ хэмжээгээ өөрөө тогтоож,

гаднын болон дотоодын олон хүнтэй харилцаж илүү ихийг, илүү сонирхолтой байдлаар суралцаж болно.

- Мэдлэг, ур чадвар, өөрийн хөгжилд нь мөн асар сайнаар нөлөөлнө.

Гэхдээ зарим тохиолдолд асуудал илэрч, боловсролын системд нөлөөлж болзошгүй. Жишээ нь: зарим газар хэт хэлбэр хөөцөлдөж боловсрол бүтээмжит байдлыг үр ашгийг бодолгүй зарим багш нэг зүйлийн үүрэг болгон үзэж боловсролын агуулгын суралцах үзэл санааг урамшуулж дийлэхгүй, цаг өнгөрөөх, хэт хувийн ашиг сонирхлыг илүүд үзэх үзэгдэл үүсэх гэх мэт. Гэвч энэ нь тухайн хүний ухамсартай холбоотой учраас шууд нөлөөлөл үзүүлнэ гэж хэлэх нь харьцангуй ойлголт юм. Үүнийг дагаад илүү боловсон, шинэ зууны иргэн болох гэсэн шинэ асуудал урган гарж болно. Энэ байдал нь хүмүүсийг илүү шахаж, нэн илүү бүтээмжтэй боловсронгуй арга зам эрэлхийлэх байдлыг бий болгожээ. Бие даан суралцах нь нэг зүйлийн заан сургалтын үйлдлээр суурь болгосон суралцахуй болсны хувьд цэцэрлэгийн багшийн ажил үйлдлийн болон суралцах үйлдлийг нягт холбогдуулж нэг талаас багшийн суралцах агуулга нь сургалтын явцад асуудал бэрхшээлээс их, нөгөө талаас тасралтгүй үйлдлийн асуудлыг шийдвэрлэж ажлын үр бүтээмжийг дээшлүүлэх явц болно. Иймээс бие даан сурах нь цэцэрлэгийн багшийн ажил болон сурах үйлдлийг уялдуулан холбож биелүүлж, ажил алба боловсролын чанарыг дээшлүүлж чадах юм.

Бие даан сурах нь цэцэрлэгийн багшийн өөрийн карьерыг дээшлүүлэх хувь хүний дотоод хэрэгцээний асуудал болох юм. Судалгаанаас харахад мэргэжлийн хөгжил нь тухайн багш мэдлэг бүтээх үйлст хамаарч таарч тохирсон, багш бүрийн өвөрмөц хэрэгцээг тусгасан ажлын байрны боломж хийгээд хязгаарыг анхаарсан нөхцөлд илүү үр өгөөжтэй байх ажээ (Берт Криймерс, Леонидас Кириакайдс, Панаиотис Антониа. 2013, х-51).

Эцсийн дүнд сурах нь тусгай мэргэжлийн багшийн ур чадварыг дээшлүүлж, мөн чанарыг сайжруулах зорилготой хэдий ч тухайн цэцэрлэг, байгууллагын үндсэн зорилго, зорилтыг хангахын төлөө байдаг. Нэг талаас бие даан сурах нь цэцэрлэгийн багшийн өөрийн хөгжлийн өөрийн бодлоор зохицуулалт хийх. Сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс авч хэлбэл бие даах чанар бол хүний хамгийн чухал чанар бөгөөд хөдлөнгүй чанарын мөн чанарын дотод агуулга юм. “Хүний зан чанарын өсөн бойжилт”-ийн гол элемент болно. Хүн бүр өөрийн “бие даах” даах

дадалд зуршилтай, бусдаас хамааралгүй байх шинжтэй байдаг. Цэцэрлэгийн багш нь насанд хүрсэн суралцагч учраас тусгай мэргэжлийн хүмүүс болсны хувьд өвөрмөц онцлог танин мэдрэхүй хэв маяг, дур сонирхол зэрэг талаар асар их ялгаатай байна. Тусгай мэргэжлийн чадвар нь бас адил бус түвшнээр илэрч байдаг. Багшийн тусгай мэргэжлийн хөгжлийн онолыг үндэслэн үзэхэд адил бус хөгжлийн шат болон, тухайн түвшний багш нарын мэдлэг боловсрол болон үүрэг, анхаарлаа хандуулах хандлага зэрэг нь бас өөр ялгаатай байна. Үүнээс үзэхэд, цэцэрлэгийн багшийн бие даан сурах нь хувь хүний санаачилгатай байдал ухамсартай нягт холбоотой юм. Багшийн тусгай мэргэжлийн хөгжил нь тухайн хүнээс хариуцлагатай чанар, бүтээлч, тууштай зан чанарыг шаардана. Уламжлалт заах аргын хандлага нь дээрээс доош шат шатаар “зарлиг буулган” албадан сургах хэв маяг ажиглагддаг. Тэр нь багшийн хувь хүний үзэл бодол шаардлагыг өчүүхэн ч бодолцдоггүй болохоор үр бүтээмж тийм ч сайн байдаггүй. Практик ажиллагаа голлосон бүтээмж өндөр бүхий багшийн тусгай мэргэжлийн багшийн тус биеийн гол чанарыг дэмжих бөгөөд сурах идэвх сонирхолтой байдлыг хөхиүлэн дэмждэг. Цэцэрлэгийн багш зөвхөн санаачилгатайгаар суралцаж тасралтгүй өөрийгөө хөгжүүлбэл тухайн багш ажилтны ажиллах урам зориг, цаашдаа илүү үр дүнтэй байхад маш том түлхэц болох юм.

### Дүгнэлт

- Техник технологи хөгжсөн XXI зуунд бие даан суралцах нь цэцэрлэгийн багш гэлтгүй хэн хүний хэрэгцээ шаардлага болоод байна. Манлайлах, удирдах, сурагчдад зөв оновчтой мэдлэг боловсрол олгоход боловсролын байгууллагын ажилчид зогсолтгүй суралцаж цаг үеэсээ хоцрохгүй байх нь зүйн хэрэг. Цэцэрлэгийн багшийн боловсролын чанарыг сайжруулах, нийгэмд өөрийн байр сууриа дээшлүүлэх зэрэгт хамгийн оновчтой арга бол бие даан суралцах арга юм.
- Цэцэрлэгийн багшийн хөгжилд сургалтын орчин нөхцөл, цалин хангамж, ажлын ачаалал зэрэг эдийн засгийн шинжтэй бэрхшээлүүд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Багшийн сурах сонирхлыг төрүүлэн, багшийн хөгжлийн бүх үеийн турш тасралтгүй урамшуулах, оюун санааны болон материаллаг дэмжлэг урамшууллыг

багшийн ажилласан жилд тохирсон хэмжээгээр үзүүлэх шаардлагатай хэдий ч нөгөө талаас багш өөрөө өөрийгөө хөгжүүлэх боломжит бүх хэлбэрийг бүрэн ашиглаж чадахгүй байна

- Хөгжихийн тулд юуг, яаж, ямар хэлбэрээр хэдийд сурч эзэмших зэрэг нь хувь багшийн чөлөөт сонголт дээр тулгуурлаж байх учиртай. Хэний ч шахалт шаардлагагүйгээр гагцхүү өөрийн хүчин чармайлт дээр түшиглэн суралцаж хөгжихийн үндэс нь өөрийн хэрэгцээ, сонирхол, нөөц бололцоондоо тулгуурлан хөгжихийн үндэс болдог хэмээн үзэж байна.
- Бидний судалгаанаас багш сургалт, семинарт суугаад мэргэжил дээшлүүлэхийн зэрэгцээ мэдээллийн эрин зуунд интернет, бусад мэдээллийн хэрэгслээр болон өөрийн ажлын туршлагад үндэслэн хөгжих нөхцөл бололцоог ашиглах нь зүйтэй байна хэмээн дүгнэж байна.

#### **Ашигласан материал**

- Амаржаргал, Х. (2012). *“Багшийн мэргэшил дээшлүүлэх асуудалд”*. Улаанбаатар
- Берт Криймерс, Леонидас Кириакайдс, Панаиотис Антониа. (2013). Багшлахуйн чанарыг сайжруулахад багшийн хөгжил. Спрингер
- Монгол Улсын Боловсролын Их сургууль. (2004). *“Сургалтын аргазүй”*. Улаанбаатар
- Монгол улсын үндсэн хууль: Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого
- “Боловсрол судлал”* сэтгүүл
- Занг Хуа, Жун Чи Чуйн (2002) *“Хичээлийн сургалтын онол”*
- Ху Би Шиа (2005). *“Тусгай мэргэжлийн багшийн хөгжилтийн тухай тайлбар”*
- Оюун, Ц., Түмэндэмбэрэл, Д. (2002). Багшийн хөгжил